

БАТЛАВ  
“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН  
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Н.МӨНГӨНХӨЛӨГТ



2024 оны 03 дугаар сарын 11

**ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХ  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ.**

2024 оны 03 дугаар сарын 11

Багануур дүүрэг

**ЗОРИЛГО**

Гамшгаас хамгаалах тухай хуульд тусгагдсан хуулийн этгээдэд холбогдох заалтыг хэрэгжүүлж тус байгууллагад болон цахилгаан хэрэглэгчдэд учирч болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах.

**ҮНДЭСЛЭЛ**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.5, 7.6 дахь заалтууд болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-д тус тус үндэслэнэ. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг 3 жил тутам, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгохтой уялдуулан тухай бүр хийнэ.

**ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ**

Д/д	Хамрагдах салбар
1	Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбар ( Ажлын байр, агуулах, автографш, дэд станц, хуваарилах байгууламж болон цахилгаан дамжуулах агаарын шугамууд)

**НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ГАМШГИЙН ТӨРӨЛ**

Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт (Засгийн газрын тогтоол 2018:327-ын 2 дугаар хавсралт)-д заагдсан дараах гамшгийн төрлүүдээр хийнэ.

1. Объектын гал түймэр
2. Газар хөдлөлт
3. Хүчтэй, хуй салхи
4. Цасан болон шороон шуурга
5. Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс үүсэх осол
6. Аянга
7. Үер
8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого
9. Бусад давагдашгүй хүчин зүйлс.

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Хууль эрх зүйн баримт бичиг	Шаардлагын төрөл, агуулга
<p style="text-align: center;">Гамшгаас хамгаалах тухай хууль</p> <p style="text-align: center;">Засгийн газрын тогтоол</p>	<p>-Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт “Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ” гэсний дагуу тусгай зөвшөөрөлтэй байх.</p> <p>-Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын</p> <p style="text-align: center;"><b>4 дүгээр зүйлийн:</b></p> <p>-4.2.2 буюу “дэд бүтэц”</p> <p>-4.2.5 буюу “үйлдвэр, үйлчилгээ” -ний чиглэлээр тус тус үнэлгээ хийх эрхтэй байх.</p> <p style="text-align: center;"><b>7 дугаар зүйлийн:</b></p> <p>-7.1.4. эрсдэлийн үнэлгээг захиалагч талтай байгуулсан гэрээнд заасан хугацаанд тогтоосон аргачлалын дагуу чанартай гүйцэтгэн үнэлгээний тайланг 3 хувь үйлдэж, захиалагч тал болон холбогдох байгууллагад хүргүүлэх;</p> <p>-7.1.5. үнэлгээний багийн гишүүд “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх;</p> <p>-7.1.6. захиалагч талын үйл ажиллагаа, техник, технологи, бизнесийн мэдээллийн нууцыг хадгалах;</p> <p>-7.1.7. эрсдэлийн үнэлгээнд баталгаатай эх үүсвэр сурвалжаас авсан мэдээ, мэдээллийг ашиглах.</p>

## ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ОНЦЛОГ ШААРДЛАГА

Шаардлага	<p>-Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний дараах туршлагатай байх:</p> <p>-Хугацаа: 3-аас доошгүй жил хийсэн.</p> <p>-Чиглэл: “Дэд бүтэц”-ийн хүрээнд Цахилгаан дамжуулах ба түгээх сүлжээнд хийсэн.</p> <p>-Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлан шаардлага хангаагүй тохиолдолд холбогдох заавар, аргачлалын дагуу дахин гүйцэтгэх шаардлагатай</p> <p>-Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг холбогдох заавар стандартын дагуу хийгдсэн байх</p> <p>-Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг дүгнэх шалгуур үзүүлэлтийг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтангаар баталгаажуулсан байх</p>
-----------	---

## ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг зааврын 3 дугаар зүйл “Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх”

А.Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд бэлтгэх

Б.Гамшгийн эрсдэлийг тодорхойлох

В.Гамшигийн эрсдэлийг шинжлэх

Г.Гамшгийн эрсдлийг дүгнэх буюу үнэлэлт өгөх гэсэн дэс дараалал, агуулгыг мөрдлөг болгож ажиллана.

Үүний зэрэгцээ үнэлгээ хийгдэж байгаа гамшгийн төрлүүдийг дээрх тушаалын холбогдох хавсралт зааврын дагуу хийнэ. Жишээ нь: Объектын гал түймрийн үнэлгээ хийхдээ “Барилга байгууламжийн гал түймрийн эрсдлийн үнэлгээ хийх аргачилсан заавар”-ыг баримтална.

### ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тайланг “Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тайланд тавигдах шалгуур үзүүлэлт (ОБЕГ-ын даргын тушаал 2021 оны А/255-ын 2 дугаар хавсралт)-д нийцүүлэн боловсруулна.

### ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гамшгийн эрсдэлийн үнэлгээнд бэлтгэх	-Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдийн төлөөлөл (үнэлгээний баг)-тэй уулзаж “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-д тусгагдсан: -Эрсдэлийн үнэлгээ хийлгэх захиалагч талын эрх, үүрэг болон эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлно.
Гамшгийн эрсдэлийн үнэлгээнд хэрэглэгдэх бичиг баримттай танилцах, мэдээлэл авах	Үнэлгээний баг үнэлгээнд шаардлагатай мэдээллийн жагсаалтыг гаргаж захиалагчид өгнө. Захиалагч жагсаалтын дагуу мэдээллийг гаргаж бэлтгэнэ. Төрийн болон байгууллагын нууц мэдээлэл байгаа бол харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийгдэж байгаа объектын судалгаа хийх	Захиалагч эрх бүхий мэргэжлийн ажилтанг объектын судалгааны хөтчөөр томилно. Үнэлгээний багийн гишүүд хөтчийн хамт явж объекттой танилцана.
Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлан боловсруулах	Бичиг баримттай танилцаж, объектын судалгаа хийсний дараа үнэлгээний баг тайлан боловсруулна. Энэ үед нэмж лавлах асуудал гарвал хөтчид хандаж тодруулна.
Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг танилцуулах уулзалт хийх	Үнэлгээний баг тайлан боловсруулж дуусаад захиалагчид танилцуулж санал хүсэлт байвал тодруулж ярилцан тайланд тусган хэвлэнэ.
Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг тушаах	Захиалагч хэвлэсэн тайлангаа орон нутгийн ОБ-ын байгууллагад хүргүүлнэ.

ХЯНАСАН:

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ЭРҮҮЛ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ

АХУЙН ХЭЛТСИЙН АХЛАХ, ХАБЭА-Н ИНЖЕНЕР

Д.ЦЭЦГЭЭ

Р.ГАНХУЯГ